

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 он

АГУУЛГА

НЭГ. НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	3
ХОЁР. НЭГЖИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	4
ГУРАВ. БИЧИГ ХЭРЭГ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР	11
ДӨРӨВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	12
ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР	15
ЗУРГАА. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАСАГ	23
ДОЛОО. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР	29
НАЙМ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР	32
ЕС. САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР	36
АРАВ. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР	37

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.12.02

Баруун-Урт хот

Тус хэлтэс нь өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газар, аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, аймгийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээ, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай хэлтсийн даргын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах багц хуулиуд, холбогдох тогтоол шийдвэр, журмуудын хэрэгжилтийг хангахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь нийт 26 ажилтан албан хаагчидтайгаар бүртгэлийн үйлчилгээг аймгийн 63.4 мянган иргэнд хүргэж байна. Тус хэлтэс нь аймгийн Нутгийн удирдлагын ордны шинээр баригдсан 2 дугаар байрны 8 давхарт 10 өрөө бүхий 200 мкв талбайтай байранд бүртгэлийн үйл ажиллагаа явуулж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын "Улсын бүртгэлийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал"-д тусгагдсан ажил, арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг ханган 2022 онд зохион байгуулсан үйл ажиллагаагаа тайлагнаж байна . Үүнд:

НЭГ. НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг “Аргачлал загвар батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг үндэслэн “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу төлөвлөгөөний төслийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан, арга хэмжээний шалгуур үзүүлэлт бүрийг тодорхой хугацаанд биелэгдэхээр төлөвлөн боловсруулж, 2000 тэмдэгтэд багтаан товч

тодорхой, бодитой, үг үсгийн алдааг хянан тогтоосон хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж батлуулсан.

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 4 зорилт, 37 арга хэмжээний хүрээнд батлагдан, хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс тасаг нэгжүүд, цаашлаад тасаг нэгжээс улсын бүртгэгч нартай төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлтсийн даргатай байгуулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллав.

ХОЁР. НЭГЖИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022 оны 5 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжлтийн нэг томоохон ажил болох тоон гарыг үсгийг олгох ажлыг аймаг орон нутагтаа зохион байгуулан ажиллаж байна.

УБЕГ-аас 2022 оны 4 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулсан тоон гарын үсэг олгох сургагч багш бэлтгэх сургалтанд иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Х.Наранчимэг хамрагдаж, сумдын улсын бүртгэгч нарт тоон гарын үсэг олгох сургалтыг 4 дүгээр сарын 28-нд онлайн хэлбэрээр эрх зүйн болон программын сургалт гэсэн 2 төрлөөр зохион байгууллаа.

Тоон гарын үсгийн олголтыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд явуулын сүлжээтэй болох талаар УБЕГ-т хүсэлт тавьж, юнителийн 4G сүлжээтэй болсоноор аймгийн хэмжээнд олгогдож байгаа тоон гарын үсгийн явц болон иргэдийн хамрагдалт өссөөр байна.

Мөн аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудаар өдөр өдрөөр хувиар гарган албан хаагчдыг бүрэн хамруулах талаар байгууллагын удирдлагуудтай урьдчилан ярьж төлөвлөгөө гарган дараах байгууллагын албан хаагчдыг хамрууллаа. Үүнд :



Аймгийн нэгдсэн эмнэлэгийн 150, Зэвсэгт хүчний 338-р ангийн 130, Ус дулааны Дөрвөлж ОНӨҮГ-ын 100, Цайрт минерал ХХК-ны 200 гаруй, аймгийн Засаг даргын тамгын газрын 50, Ерөнхий боловсролын 1,2,3,4 дүгээр бүрэн дунд сургуулийн 300 орчим багш ажилчин албан хаагчдад, аймгийн хөгжимт жүжгийн Жаахан шарга, ХААН, Хас, Голомт банкны 100 орчим ажилчин албан хаагчдад тус тус тоон гарын үсгийн хэрэглээ, ач холбогдолын талаар бүх ажилчдын хурал дээр мэдээлэл танилцуулга хийж, тоон гарын үсэг олгож ажиллалаа.



Аймгийн хэмжээнд 16 ба түүнээс дээш насны 43000 иргэн байгаагас жилийн эцсийн байдлаар 4910 иргэнд буюу нийт иргэдийн 11.4 хувь нь хамрагдаад байна.

13 сумын хэмжээнд тоон гарын үсгийг олгох ажлыг сумдын засаг даргын тамгын газартай хамтран төрийн үйлчилгээний лавлагаа өгч байгаа ажилтанаар дамжуулан emongolia системээс лавлагаа авч байгаа иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Аймаг сумдын иргэдэд тоон гарын үсгийн талаар мэдээлэл хүргэх үүднээс орон нутгийн BBS телевизд 10 минутын мэдээлэл, яриа өгсөн.

13-ны өдөр эцсийн байдлаар хэвлэж дуусгалаа. СНЖ-тад лавлагаа бүртгэгдээгүй, нийт сонгогч 331, үндсэн сонгогч 331 бүртгэгдсэн байна.

Нийт 11 хуудас бүхий сонгогчийн нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэж, хэлтсийн дарга, улсын бүртгэгчийн гарын үсэг тамга тэмдэгээр баталгаажуулан, сонгогчийн нэрсийн жагсаалт хүлээлцэх акт болон тоног төхөөрөмж, код хүлээлцэх, компьютер тоног төхөөрөмж лацдсан тухай актуудыг тус тус үйлдэж сумын сонгуулийн хороо болон итгэмжлэгдсэн ажилтанд тус бүр нэг хувийг хүлээлгэн өгсөн.

2022 оны 02 сараас эхлэн Мөнххаан, Эрдэнэцагаан сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч ажиллаж эхэлсэнээс сум орон нутагтаа нийт 450 мэдүүлэг хүлээн авч бүртгэл хөтөлсөн байна.

УБЕГазар нь цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар үйлчилгээний чанар хүртээмж шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд барьцааны гэрээ, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, барьцааны гэрээг дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх, эрхийн улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг хөнгөн шуурхай хялбар болгох ажлыг 2022 оны 06 сарын 02-ны өдрөөс эхлэн бүртгэсэнээс хойш нийт 564 барьцааны гэрээ бүртгэсэн байна.

Бүгд найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль батлагдсан 98 жилийн ойн баярыг тохиолдуулан Монгол Улсын ерөнхий сайдын ивээл дор 20 дахь жилдээ “Иргэн андгай өргөх” ёслолын үйл ажиллагааг Сүхбаатар аймагт зохион байгууллаа.

Энэ жил улсын хэмжээнд 16 нас хүрч Иргэний үнэмлэхээ гардан авч байгаа 44.331, аймгийн хэмжээнд 687 өсвөр үеийн залуус байгаа бөгөөд тэдгээрийн төлөөлөл 64 хүүхэд ёслолд оролцлоо.



Төрийн захиргааны 22 албан хаагчдын 2021 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогийн мэдүүлгийг цахим болон цаасан хэлбэрээр гаргуулан баталгааны маягыг албажуулан авсан. Мөн тайлант онд шинээр томилогдсон болон хүүхэд асрах чөлөөтэй байж байгаад ажилдаа орох хүсэлт гаргасан албан хаагчдаас хуулийн хугацаанд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогийн мэдүүлгийг цахим болон цаасан хэлбэрээр гаргуулан баталгааны маягыг албажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан хэлтсийн албан хаагчдын хүүхдүүдэд гарын бэлэг гардууллаа.

Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх үүднээс хэлтсийн үйлчилгээний танхимд үйлчилгээний хураамжийн киоск машин, ХААН банкны пос машин, цахим үйлчилгээний буланг тогтмол ажиллуулж байна. Жилийн эцсийн байдлаар киоск, болон пос машинаар төлбөр төлсөн 3075 орчим иргэн, 24.465.300 мянган төгрөгийн үйлчилгээний хураамжийг төлсөн байна.



Хэлтсийн угтах үйлчилгээний ажилтан цахим үйлчилгээг хариуцан ажиллаж байгаа бөгөөд E-Mongolia, Opendata-аар дамжуулан иргэний улсын бүртгэлийн чиглээр 80, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 102, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 70, бусад төрлийн лавлагаа 61, нийт 320 иргэнд лавлагаа олгож ажиллалаа.

Мөн угтах үйлчилгээний ажилтан нь иргэдэд бүртгэлийн үйлчилгээг ойртуулахад шаардлагатай мэдээ мэдээллийг хүргэх, бүрдүүлэх материалын жагсаалт болон иргэдэд бүртгэлийн зөвлөмж, чиглүүлэх үйлчилгээг үзүүлж, давхар албан хаагчдын цаг бүртгэлийг хянаж гадуур ажлын дэвтэр хөтлөх зэрэг ажлуудыг өдөр тутамдаа хийж гүйцэтгэж байна.

2020 онд Улсын бүртгэлтийн байгууллага үүсч хөгжсөний түүх 80 жилийн ойн хүрээнд 80 ширхэг мод суулган УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС-ийн төгөлийнхөө ургаагүй мод бутад нөхөн сэргээлт хийж нэмэлтээр Баруун-Урт сумын 1-р багийн нутаг дэвсгэрт 20 ширхэг үхрийн нүд тарьлаа.



Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь “Хог хаягдлын тухай” хууль, Хүн амын эрүүл мэнд, хотын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор хуваарьт газар болох Хүүхдийн тоглоомын талбайн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэлээ.



Иргэдийн санал хүсэлт, бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой зөвлөгөө мэдээлэл хүргэх зорилготой 70512673 дугаар утсанд нийт 105 иргэн холбогдож иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн үйлчилгээ архивын лавлагаа үйлчилгээтэй холбоотой мэдээллийг тус тус хүргэж шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний тасгаас Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж байгаа агентлаг төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын хүрээнд аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн засаг даргын захирамж, албан даалгаварын биелэлт, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт зэрэг тайлангуудыг 2022 оны хагас болон жилийн эцсийн байдлаар гарган тус тасагт тогтмол тайлагнан ажиллаж байна.

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг ханган sukhbaatar.burtgel.gov.mn сайт болон Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нүүр хуудас, үйлчилгээний заалны мэдээллийн самбараар дамжуулан иргэдэд бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах, бүрдүүлэх материалын жагсаалт зэргийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Мөн энэ онд мэдээллийн самбарыг үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, үйл ажиллааны болон хүний нөөцийн чиглэлээр төрөлжүүлэн иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг ил тод нээлттэй хүргэж байна.

Мөн мэдээллийн самбар тус бүрт иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах саналын хайрцагийг байршуулан, самбар тус бүр дээр цахим хаяг, вэб сайт, утасны дугаар, мэйл зэргийг хэвлэн иргэдийг цахимаар үйлчлүүлэх нөхцөл бололцоог ханган ажиллаж байна.



2022 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар Улсын бүртгэлийн хэлтэс нь улсын төсвөөс 361,5 сая төгрөгийн санхүүжилт авч 344,8 сая төгрөгийн зардал гаргаж 16,6 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Мөн энэ онд улсын төсөвт 110,0 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байсанаас 11 сарын байдлаар 103,0 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан байна. Монгол улсын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд шилэн дансны сайтад хэлтсийн байршуулах ёстой бүх мэдээлэлээ хуулийн хугацаанд байршуулсан.

Байршуулаагүй болон хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй болно. Сар бүрийн 02-ны дотор төсвийн гүйцэтгэлийн мэдээ, үнэт цаасны тайланг УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлэн байгууллагын шилэн дансны мэдээлэлийг сар бүрийн 8-ны дотор шилэн дансны сайтад бүрэн байршуулан ажилласан.

2021 оны санхүүгийн тайлангийн аудитад акт, албан шаардлага, зөвлөмж аваагүй зөрчилгүй санал дүгнэлт авч санхүүгийн сахилга батыг эрхэмлэн МУ-ын төсвийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 2022 онд тэвчиж болох боломжит бүх зардлаа хэмнэж жирэмсэн амаржсан албан хаагчдын албан тушаалын орон тоон дээр хүн аваагүй цалингийн хэмнэлт үүсгэн ажилласан.

Жилийн эцсийн байдлаар хэлтсийн хэмжээнд нийт 20 өргөдөл гомдол хүлээн авсанаас албан хаагчдын нийгмийн асуудал хүний нөөцтэй холбоотой асуудлаар 8, иргэний бүртгэлийн чиглэлээр 4, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 6, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 2 тус тус хүлээн авч хуулийн хугацаанд шийлвэрлэсэн байна. Нийт 20 өргөдлийг 100 хувь үнэн зөв гарган шийдвэрлэсэн.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лаборторийн баг Сүхбаатар аймагт ирж ажиллахад хэлтсийн нийт албан хаагчдыг элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд бүрэн хамрууллаа.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан албан хаагчдад зуслангийн зориулалтаар газар өмчлөх, эзэмшүүлэх ажлын хүрээнд аймгийн засаг дарга М.Идэрбаттай цаг авч уулзан, санал хүсэлтээ уламжилж ажил хэрэг болгох талаар хамтран ажиллахаар тохиролцлоо. Мөн байгууллагын зүгээс албан хаагчдад дэмжлэг үзүүлэх үүднээс бага насны нэг хүүхдийн төрсөн өдрөөр цалинтай чөлөө олгож байна.

Мөн Цайрт минерал ХХК-ны удирдлагатай уулзаж төрийн байгууллагын үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлж хамтран ажиллах, дэмжлэг хүсч өөрийн байгууллагын онцлог, одоогийн нөхцөл байдалаа танилцуулж, үйл ажиллагаандаа хэрэглэх олон үйлдэлт каноны дэмжлэгийг хүлээн авсан.

2022 оны 9 дүгээр сарын 10, 11 өдрүүдэд “Найрсаг-Баруун-Урт” Нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд сурталчилж, бүртгэлийн үйлчилгээний бүрдлүүлэх материалын жагсаалт болон гарын авлага, тоон гарын үсгийн хэрэглээг тус тус 500 орчим иргэдэд сурталчилж ажиллалаа.



ГУРАВ. БИЧИГ ХЭРЭГ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

2022 оны жилийн эцсийн байдлаар иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 22 чиглэл, албан даалгавар 9, Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тогтоол 1, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд баримтлах журам 1 ирж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Хэлтсийн даргын байгууллагын боловсон хүчинтэй холбоотой 16, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 13 тушаалын шийдвэрийн төсөлд санал авах хяналтын дагалдах хуудсаар баталгаажуулж, албажуулан гаргасан.

Хэлтсийн хэмжээнд нийт 20 өргөдөл, гомдол бүртгэгдсэн. Үүнд: хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 2, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 6, иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 4, албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт 8 тус тус хүлээн авч бүртгэл хөтөлсөн. Нийт өргөдөлийн шийдвэрлэлт 100 хувь, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.

2022 оны жилийн эцсийн байдлаар хэлтсийн хэмжээнд нийт цаасаар 110, цахим хаяг буюу sukhbaatar@burtgel.gov.mn хаягаар 530 гаруй албан бичиг хүлээн авсан. Нийт 640 бичигнээс хариу хүргүүлэх шаардлагатай 202 бичгэнд хугацаанд нь хариу хүргүүлж шийдвэрлэлтийн байдал 100 хувь.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/705 тоот тушаалаар баталсан Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт, Хөдөлмөрийн дотоод журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Ёс зүйн арга хэмжээ авагдсан хоёр албан хаагч байгаа болно.

2022 оны жилийн эцсийн байдлаар даргын зөвлөлийн хурлыг 3 удаа хуралдаж тэмдэглэл хөтлөн баталгаажуулсан.

Аймгийн удирдах ажилтны хурлаас гарсан шийдвэрийг танилцуулах хурлыг 7 хоног бүрийн мягмар гарагт зохион байгуулж нийт 7 удаа танхимаар сумдын улсын бүртгэгч нартай цахимаар холбогдож тэмдэглэл хөтлөн баталгаажуулсан.

Эрдэнэцагаан, Мөнххаан сумдын бүртгэгч нар эд хөрөнгийн эрхийн бүртгэл хийх сургалтанд цахимаар хамрагдсан. Эрдэнэцагаан сумын улсын бүртгэгч Ц.Содцэцэг, Мөнххаан сумын улсын бүртгэгч Т.Отгонцэцэг нар эд хөрөнгийн эрхийн бүртгэл хийх шалгалт өгч тэнцсэн. Суманд эд хөрөнгийн бүртгэл хийж ажиллаж байна.

www.sukhbaatar.burtgel.gov.mn сайтын “Хэрэглэгч” танд булангийн “Нээлттэй ажлын байрны зар” хэсэгт гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын зар 3, удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтын зар 1, үйлчилгээний гэрээт ажилтан сонгон шалгаруулах зар 1 удаа байршуулсан байна.

ДӨРӨВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа, хууль дүрэм журам, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг www.sukhbaatar.burtgel.gov.mn цахим болон www.facebook.com/suburtgel фэйсбүүк хуудсанд 180 удаа байршуулсан.

2022 оны хагас жилийн байдлаар Төрийн албаны зөвлөлийн 12 удаагийн 4:7:10 буюу вэбинар сургалт, УБЕГ болон орон нутгийн байгууллагуудаас танхимын болон онлайнаар дараах сургалтуудад тогмол хамрагдаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан сургалтууд:

1. 2022.01.27-нд Иргэний бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдолтой хууль тогтоомжийн сургалт
2. 2022 оны 02 сард сумдын 2 эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчид 5 өдрийн дадлага сургалт зохион байгуулсан.
3. 2022.03.11-нд Авлигатай тэмцэх газраас төлөвлөгөөт сургалт
4. 2022.03.22-нд Хувь хүний мэдээлэл цуглуулах арга
5. 2022.03.22-нд Төрийн үйлчилгээний албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт
6. 2021.03.31-нд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдолтой хууль тогтоомжийн сургалт
7. 2022.04.02-нд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан сургалт
8. 2022.04.10-нд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 21 аймаг дахь улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулсан сургалт
9. 2022.04.14,15-нд Тоон гарын үсэг олгохтой холбогдолтой сургагч багш бэлтгэх сургалт
10. Бусад байгууллагатай хамтарсан суралт буюу Удирдлагын академийн сургалт
11. 2022.05.31-нд Хяналтын улсын байцаагч нарыг мэргэшүүлэх зэрэг сургалтууд

Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтууд:

1. Аймгийн засаг даргын тамгын газраас Хяналт шинжилгээ үнэлгээнд ирүүлэх мэдээ тайлангийн программын сургалт
2. Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас “Сайн дурын ажилтан бэлтгэх” сургалт
3. Хүний нөөцийн суурь судалгааны үр дүнг танилцуулах сургалт
4. Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогын сургалт
5. 2022 оны 11 сарын 23 өдөр “Захиргааны шийдвэр гаргалт дээр анхаарах асуудал” сургалт
6. 2022 оны 11 сарын 25-нд “Барилгын яам, барилгын хөгжлийн төв, ЭХЭУБГазрын хамтарсан сургалт ЭХЭУБүртгэгч нарт зориулсан
7. 2022 оны 11 сарын 30-ны өдөр ЭХЭУБүртгэлийн нийт албан хаагчдад зориулсан “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт”

8. 2022 оны 11 сарын 18-ны өдөр Тагнуулийн ерөнхий газрын Сүхбаатар аймаг дахь хэлтсээс “Төрийн болон албаны нууцын тухай хууль, Монгол улсын төрийн болон албаны нууцын хамгаалах нийтлэг журам, Кибер аюулгүй байдлын тухай хууль”-д заасны дагуу сургалтанд онлайнаар нийт албан хаагчид бүрэн хамрагдсан.

Дотооддоо сургалт зохион байгуулсан байдал:

2022 оны хэлсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдын боловсрол, мэргэжил, ур чадварыг сайжруулах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нийт албан хаагчдыг баг болгон төрийн албан хаагчын богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөртэй уялдуулан сургалтын сэдвийг сонгож ажлын байран дахь сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар :

2022.04.12-нд “Харилцааны соёл” сэдвээр Асгат, Баруун-Урт, Баяндэлгэр сумд

2022.04.26-нд “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр Наран, Онгон, Мөнххаан сумд

2022.05.10-нд “Байгууллагын соёл уур амьсгал” сэдвээр Түвшинширээ,Түмэнцогт, Уулбаян сумд

2022.05.24-нд “Баг бүрдүүлэх багаар ажиллах чадвар” Сүхбаатар, Халзан, Дарьганга, Эрдэнэцагаан сумд

2022.06.14-нд “Шийдвэр гаргах” сэдвээр Д.Сайнбаяр, Г.Оюунжаргал нар тус тус илтгэл бэлдэж, албан хаагчдад сургалт хийлээ. Цаашид төлөвлөгөөний дагуу бүх албан хаагчид оноогдсон сэдвийн дагуу сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Монгол улсад Бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 82 жилийн ойг тохиолдуулан Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсээс 2022.11.22-2022.11.23 өдрүүдэд бүх сумдын бүртгэгч, албан хаагчдад зориулан "СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ"-ийг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлгээр аймгийн хэмжээнд Улсын бүртгэгч нарт тулгарч байгаа асуудал, орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг

даалгавар, шинээр батлагдсан хууль, дүрэм журмын талаар ярилцаж санал бодлоо солилцон ажиллаа. Мөн сургалт, хэлэлцүүлэгт хуульч У.Болдхүү цахимаар хууль эрх зүйн талаар зөвлөмж хүргэлээ.



ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч Н.Бадрахцог нь 2022 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө болон ажлын байрны тодорхойлолтонд заагдсан Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих чиг үүргийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Бодлого зорилтыг хангах чиглэлээр:

Тайлант хугацаанд хяналт, шалгалтын ажлыг хэрэгжүүлэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хөрөнгийн тухай хууль болон холбогдох хууль, журам, дүрэм, заавруудыг үйл ажиллагаандаа удирдлага болгон хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн төрийн албан

хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын үйлчилгээний стандарт, хөдөлмөрийн дотоод журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтыг хийж, ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын үйл ажиллагаандаа иргэдээс улсын бүртгэлтэй холбоотой гаргасан өргөдөл, гомдол болон улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэлд зөрчлийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн ажилласан болно.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Иргэний бүртгэлийн тасаг нь 2022 онд өссөн дүнгээр 7493 бүртгэл, 4394 лавлагаа, 10866 хуудас бүхий эх нотлох баримтыг цахимжуулж ажилласан байна.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт ИТХ-ын нөхөн сонгууль зарласантай холбоотойгоор сонгогчийн нэрсийн жагсаалтыг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр эцсийн байдлаар хэвлэж дуусгасан. СНЖ-тад лавлагаа бүртгэгдээгүй нийт 331, үндсэн сонгогч 331 бүртгэгдсэн байна.

Нийт 11 хуудас бүхий сонгогчийн нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэж, хэлтсийн дарга, улсын бүртгэгчийн гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулан, сонгогчийн нэрсийн жагсаалт хүлээлцэх акт болон тоног төхөөрөмж, кодыг тус тус хүлээлцэж, компьютерь тоног төрөөрөмжийг лацдсан тухай актыг үйлдэж сумын сонгуулийн хороо мөн итгэмжлэгдсэн ажилтан тус бүрд нэг хувийг хүлээлгэн өгсөн болно.

Хяналтын байцаагчийн дүгнэлтээр:

1. Регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай -5
2. Бүртгэл хүчингүй болгох-2
3. Бүртгэлд засвар өөрчлөлт хийх тухай-26 дүгнэлтийг тус тус гаргасан байна.

Хуулийн хэрэгжилтийг хангаж, бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд нийт 1267 бүртгэлд хяналт тавьсан байх ба 126 зөрчлийг илрүүлэн арилгах арга хэмжээ авч ажилласан болно.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын бүртгэлийн тасгийн 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хийгдсэн бүртгэлд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын

баталсан эрсдэлд суурилсан улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамжийн дагуу Хяналт шалгалтын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 7/9579 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 819 бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичиг цахимжсан эсэхийг шалгахад дээрх зөрчил илэрээгүй болно.

Удирдамжийн дагуу хийсэн шалгалтад иргэний улсын бүртгэлийн санд тухайн хугацаанд хийгдсэн бүртгэлүүдийн эх нотлох баримт бичиг цахимжсан эсэхэд ямар нэг зөрчилтэй хийгдсэн бүртгэл хийгдээгүй байсан боловч цаашид анхаарах болон авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлууд байгаа нь тогтоогдсон тул хэлтсийн нийт албан хаагч нарын сургалтан дээр бүртгэл тус бүр дээр анхаарах асуудлуудыг цаашдын үйл ажиллагаандаа баримтлан ажиллахыг сануулсан болно.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан өдөр тутмын болон түүвэрчилсэн мөн иргэд, хуулийн этгээдийн зүгээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой гаргасан өргөдөл гомдол, хүсэлтийн дагуу хийсэн хяналт шалгалтаар эрхийн улсын бүртгэлийн 705 бүртгэлд хяналт шалгалтын үйл ажиллагааг хяналт шалгалт хийх журмын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг 2022 онд 3870 бүртгэл, 102 лавлагааг олгон хийж, иргэд хуулийн этгээдэд эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

2022 оны 02 дугаар сараас эхлэн Сүхбаатар аймгийн Мөнххаан, Эрдэнэцагаан сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг дээрх сумдын улсын бүртгэгч нар хийж эхэлсэн бөгөөд одоогоор Эрдэнэцагаан сумын улсын бүртгэгч Дарьганга сумын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг хийж эхэлсэн бол Мөнххаан сумын улсын бүртгэгч Түмэнцогт, Түвшинширээ сумдын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг давхар хийж гүйцэтгэж эхэлсэн тул дээрх сумдын бүртгэгч нарын хийж байгаа бүртгэлд давхар хяналт шалгалтын үйл ажиллагааг хяналт тавин ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 7/2971 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цаасан хувийн хэргийг цахим мэдээллийн сантай тулган шалгаж илэрсэн зөрчлийг хяналтын улсын ахлах байцаагчийн 1500 дүгнэлтээр засвар өөрчлөлт оруулсан бүртгэлийг шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн өмчлөгчийн мэдээлэл буруу бүртгэгдсэн, үйлчилгээний төрөл, зориулалт өөрчилсөн, регистрийн дугаар буруу орсон, барьцаалагчийн мэдээлэл ороогүй, өмчлөгчийн мэдээлэл дутуу орсон, үйлчилгээний төрлийг буруу сонгосон, үйлчилгээний дараалал алдагдсан, барьцааны гэрээ давхар орсон, барьцаалагчийн нэр буруу орсон, үйлчилгээний байршил солигдож орсон, хаяг буруу цахимжуулалтын үйл ажиллагаатай холбоотой алдаатай цахимжсан хувийн хэрэгт хяналтын улсын ахлах байцаагчийн 1500 дүгнэлтээр бүртгэлд оруулсан засвар өөрчлөлт үнэн зөв, бүрэн гүйцэт тусгаж оруулсан эсэхийг шалгаж хяналт тавьж ажилласан.

2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/14 дугаар тушаалаар Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн архив байгаа эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн /Газрын 7961 ширхэг хувийн хэрэг, Үл хөдлөх эд хөрөнгийн 7465 ширхэг хувийн хэрэг/ нийт 15617 ширхэг хувийн хэргийг тоолох комиссын үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан болно.

Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгасан зөрчил нь:

1. Эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох-12
2. Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай -6
3. Хувийн хэргийн буцаалт хийх тухай -5

Хяналт шалгалтын газраас 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 09-ны өдрийн хүртэлх улсын бүртгэл түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмд нийцсэн эсэхийг хянаж шалгахад илэрсэн зөрчлийг улсын байцаагчийн албан шаардлагын дагуу арилгаж ажиллан ажиллаж байна. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт,

найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн улсын бүртгэлийн тасгийн 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хийгдсэн бүртгэлд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан эрсдэлд суурилсан улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамжийн дагуу Хяналт шалгалтын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 7/9579 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 430 бүртгэлийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичиг цахимжсан эсэхийг шалгахад дээрх зөрчил илэрээгүй болно.

Удирдамжийн дагуу хийсэн шалгалтад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн санд тухайн хугацаанд хийгдсэн бүртгэлүүдийн эх нотлох баримт бичиг цахимжсан эсэхэд ямар нэг зөрчилтэй хийгдсэн бүртгэл хийгдээгүй байсан боловч цаашид анхаарах болон авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлууд байгаа нь тогтоогдсон тул хэлтсийн нийт албан хаагч нарын сургалтан дээр бүртгэл тус бүр дээр анхаарах асуудлуудыг цаашдын үйл ажиллагаандаа баримтлан ажиллахыг сануулсан болно.

Эрхийн улсын бүртгэлийн хувьд урьд өмнө хийгдсэн бүртгэлийн алдаатай төлөв болон бүртгэлийн төрөл буруу, үйлчилгээний нэршлийг буруу оруулсан зөрчилтэй бүртгэлийг тухай бүр нь дараачийн үйлчилгээг хийхээс өмнө өмнөх алдаа зөрчлийг арилгуулсны дараа үйлчилгээг цахим мэдээллийн санд оруулж байхгүй бол бүртгэл үнэн зөв байх зарчим алдагдах нөхцөл байдлыг үүсгэж байгааг нийт улсын бүртгэгч нарт сануулан дараагийн шалгалтаар дээрх байдал үүсгэсэн байвал алдаанд тооцохыг анхааруулав.

Мөн эрхийн улсын бүртгэлд нэгж талбарын дугаарыг оруулаагүй урьд өмнө хийгдсэн бүртгэлийн алдаа зөрчлийг арилган дараачийн үйлчилгээг ороход нэмэлтээр нотлох баримтыг өмчлөгчөөс авч бүртгэлийг хийж байхыг болон шаардлага хангахгүй хэт бүдэг хэвлэгдсэн нотлох баримтыг цахим мэдээллийн санд оруулах байдал байгааг анхааран цаашид үйл ажиллагаандаа анхааран ажиллахыг сануулав.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Тайлант хугацаанд орон нутгийн өмчийн тооллоготой холбоотойгоор хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгүүлээгүй, зөрчилтэй төрийн байгууллагуудыг бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулан нийт 32 төрийн байгууллага гүйцэтгэх удирдлагын мэдээлэлд орсон өөрчлөлтийг бүртгүүлсэн.

Улсын Их Хурлын 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Татварын ерөнхий хууль /шинэчилсэннайруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг тус тус баталсантай холбогдуулан тус хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 04 сарын 26-ны өдрийн 1/3681 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг хяналтандаа авч эцсийн өмчлөгчийн мэдээллийг нөхөн бүртгэх ажлыг эрчимжүүлэх ажлыг төлөвлөгөө гарган батлуулж, нийт 13 суманд хэлтсийн нийт улсын бүртгэгчдээр дамжуулан утсаар холбогдох, орон нутгийн телевиз болон цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх байдлаар хамтран зохион байгуулж хэрэгжүүллээ. Эцсийн өмчлөгчийн нөхөн бүртгэлд хамрагдах шаардлагатай нийт хуулийн этгээдээс өссөн дүнгээр 519 хуулийн этгээдийг хамруулсан байна.

Хоршооны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 40 дүгээр тогтоол гарсан. Энэхүү хууль, тогтоол болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын даргын 2022.05.17-ны өдрийн 5/4327 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг удирлага болгон хуулийн хэрэгжилтийг хангана жиллах, хоршооны шинэчилсэн дүрмийг улсын бүртгэлд бүртгэх, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутаг дахь Хоршоодын нэгдсэн холбоо, ХХААГ-н ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, хоршоодын дарга нартай хамтран ажиллаж байна. Одоогоор 50 орчим хувь нь хоршоонь шинэчилсэн дүрмээ бүртгүүлээд байна.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хийгдсэн бүртгэлд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан эрсдэлд суурилсан улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хийх хяналт

шалгалтын удирдамжийн дагуу Хяналт шалгалтын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 7/9579 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 16 бүртгэлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичиг цахимжсан эсэхийг шалгахад дээрх зөрчил илэрээгүй болно.

Удирдамжийн дагуу хийсэн шалгалтад хуулийн этгээдийн улсын бүртгэлийн санд шалгалтад хамаарах хугацаанд хийгдсэн бүртгэлүүдийн эх нотлох баримт бичиг цахимжсан эсэхэд хянал шалгалтыг хийхэд ямар нэг зөрчилтэй хийгдсэн бүртгэл хийгдээгүй байсан боловч цаашид анхаарах болон авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлууд байгаа нь тогтоогдсон тул хэлтсийн нийт албан хаагч нарын сургалтан дээр бүртгэл тус бүр дээр анхаарах асуудлуудыг цаашдын үйл ажиллагаандаа баримтлан ажиллахыг сануулсан болно.

Архивын улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгж буюу хуудас баримт бичгүүдийг хэлтсийн дэргэд эх комиссын хурлаар хэлэлцэж, баталсан шийдвэрийн дагуу 2020 оны баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар, хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгжийн жагсаалтыг бүрэн гүйцэт тоолон хадгалах хугацааны нэрийн жагсаалт үйлдэн 3295 хуудас баримт бичгүүдийг устгасан актыг 2022.03.22 өдөр 161 тоот албан бичгээр дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

Торгууль, шийтгэвэр:

Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн иргэн хуулийн этгээдийг хуулийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй, тогтоосон хууль, журам зөрчсөн, үндэсний энгийн гадаад паспорт, цахим иргэний үнэмлэх үрэгдүүлсэн, гэмтээсэн, иргэний үнэмлэх болон үндэсний энгийн гадаад паспорт, иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг олгох, эзэмших, ашиглах, хадгалах, шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам зөрчсөн, иргэн хуулийн этгээд тамга, тэмдэг үйлдвэрлэх, хэрэглэх, хадгалах журам зөрчсөн үндэслэлээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.20-д “улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 8.1

дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 8.2 дугаар зүйлийн 2, 6, 7, 10.20 дугаар зүйлийн 1, 15.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 15.23 дугаар зүйлийн 1.1, 15.24 дүгээр зүйлийн 1, 2, 4 дэх хэсэгт заасан зөрчлийг гаргаж зөрчсөн 225 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэн төсөвт нийт 4.605.000 төгрөг оруулсан байна.

Мөн Өргөдөл гомдлын шийдвэрлэлт мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт: Тайлант хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэдээс нийт 79 өргөдөл ирсэн байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь авч үзвэл:

- Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар -33
- Эд хөрөнгийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар -25
- Хуулийн этгээдийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар -2

• Хяналт шалгалтын ажлын тайлан, тоон мэдээг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж, Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны статистик мэдээг сар бүрийн Хэлтсийн даргад болон Хяналт шалгалтын газарт, хялбаршуулан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн шийтгэл оногдуулсан тухай мэдээг Хяналт шалгалтын газар, Прокурорын газарт, хэлтсийн нягтлан бодогчид, Хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг Тамгын газарт, Үнэт цаасны мэдээг санхүүд тус тус хуулийн хугацаанд бүрэн хүргүүлж, ажиллаж байсан. Сүүлд Хяналт шалгалтын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны статистик мэдээг сар бүрийн Хэлтсийн даргад болон Хяналт шалгалтын газарт, хялбаршуулан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн шийтгэл оногдуулсан тухай мэдээг Хяналт шалгалтын газар, Прокурорын газарт, хэлтсийн нягтлан бодогчид хүргүүлж байгаа бөгөөд Хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг Тамгын газарт, Үнэт цаасны мэдээг УБЕГазарт хүргүүлэхгүй орон нутгийн нягтлан, нярав нарт гаргаж өгч байна.

- Зөрчлийн тухай судалгаа мэдээ тайланг сар бүр Хяналт шалгалтын газарт болон Сүхбаатар аймгийн прокурорын газрын хяналтын прокурорт тухай бүр гаргаж танилцуулж ажилласан бөгөөд дээрх хугацаанд аймгийн зөрчлийн хэргийг хянаж байгаа хяналтын прокурорын зүгээс дээрх хугацаанд

хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн нийт торгуулийн материалыг татан авч шалгасан.

Сургалтад хамрагдсан байдал:

УБЕГ -аас зохион байгуулсан: 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр “Улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар, өөрчлөлт оруулах тухай хяналтын улсын байцаагчийн дүгнэлт сэдэв” цахим сургалтад хамрагдсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас нийт зохион байгуулсан 6 цахим сургалт болон Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан Хяналтын байцаагч нарын эрх зүйн 2 өдрийн сургалтад хамрагдсан болно.

Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг нийтэд сурталчлах зорилгоор 2500 гаруй иргэн хуулийн этгээдэд холбогдох улсын бүртгэлийн талаар хуульд заасан журмын дагуу зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Үүнд: Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн талаар болон Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд гарч буй зөрчил, түүнийг таслан зогсоох, Зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх талаар 3 удаа сургалт зохион байгуулсан, олон нийтэд орон нутгийн телевиз, радиогоор 1 удаа, улсын бүртгэлийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн талаар танин мэдүүлсэн, мэдээлэл хүргэсэн байна.

ЗУРГАА. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАСАГ

Иргэний бүртгэлийн тасаг нь 2022 оны хагас жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 7493 бүртгэл, 4394 лавлагааг иргэд, хуулийн этгээд, төрийн байгууллагад олгон ажилласан.

Энэ онд тус аймгийн Сүхбаатар сумын 5-р багийн нутагт дэвсгэрт ИТХ-ын нөхөн сонгууль зарлагдсантай холбоотойгоор сонгогчийн нэрсийн жагсаалтыг 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдөр эцсийн байдлаар хэвлэж дуусгалаа. СНЖ-тад лавлагаа бүртгэгдээгүй, нийт сонгогч 331, үндсэн сонгогч 331 бүртгэгдсэн байна.

Нийт 11 хуудас бүхий сонгогчийн нэрийн жагсаалтыг 3 хувь хэвлэж, хэлтсийн дарга, улсын бүртгэгчийн гарын үсэг тамга тэмдэгээр баталгаажуулан, сонгогчийн нэрсийн жагсаалт хүлээлцэх акт болон тоног төхөөрөмж, код хүлээлцэх, компьютер тоног төхөөрөмж лацдсан тухай актуудыг тус тус үйлдэж сумын сонгуулийн хороо болон итгэмжлэгдсэн ажилтанд тус бүр нэр хувийг хүлээлгэн өгсөн

Нөхөн сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа ажлуудын талаарх илтгэх хуудасыг тухай бүр УБЕГ-т болон иргэний улсын бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Х.Наранцэцэгт тухай бүр илтгэх хуудсыг хүргэн ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа сар бүрийн 27-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын хэмжээнд нэгтгэн УБЕГ-ын Улсын бүртгэгч Ж.Нарантуяад j.narantuya@burtgel.gov.mn хаягаар, иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааны мэдээг сар бүрийн 26-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын хэмжээнд нэгтгэн Иргэний бүртгэлийн нэгдсэн архивын ахлах мэргэжилтэн Я.Мөнхтулга ya.munkhtulga@burtgel.gov.mn хаягаар мөн Иргэний бүртгэлийн тасгийн сар бүрийн тайланг n.narantsetseg@burtgel.gov.mn хаягаар тус тус хүргүүлэн ажиллаж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлыг тоон мэдээгээр аймгийн хэмжээнд нэгтгэвэл:

- төрсний бүртгэлд 1098 хүүхэд бүртгүүлснээс 549 нь эрэгтэй, 549 нь эмэгтэй,
- гэрлэлтийн бүртгэл 214
- гэрлэлт дуусгавар болсоны бүртгэл 35 бүртгэгдсэнээс захирааны журмаар 5, шүүхийн журмаар 30
- Монгол улсын иргэнд хүүхэд үрчлэлтийн бүртгэл 31
- Эцэг тогтоолтын бүртгэл 66
- Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрээ сольсоны бүртгэл 46
- Нас барсны бүртгэл 277
- 16 нас хүрч иргэний үнэмлэхээ захиалсан бүртгэл 735
- Иргэний үнэмлэхний дахин олголт 173
- Иргэний үнэмлэхний 25,45 насны сунгалт 1352

- Үндэсний энгийн гадаад паспорт захиалга 487
- БНХАУ-д зорчих нэг удаагийн үнэмлэх олголт 0
- БНХАУ-д зорчих олон удаагийн үнэмлэх олголт 0
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 639
- Регистерийн дугаарын өөчлөлтийн бүртгэл 6
- Аймаг доторх шилжилт хөдөлгөөн 2281

Иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааг нэгтгэвэл :

- Албан хэрэгцээнд 4045
- Хууль хяналтын байгууллагад 369
- Иргэнд 3995
- Төрийн болон төрийн бусад байгууллагад өгсөн лавлагаа 0

Жил бүр сургууль цэцэрлэгийн бүртгэл эхлэх цагаар иргэний шилжилт хөдөлгөөний зөрүүтэй байдлаас иргэд Улсын бүртгэлийн хэлтэс хооронд үл ойлголцол, маргаан үүсдэг учир энэ байдлаас урьдчилан сэргийлэх мөн үүнтэй холбоотойгоор шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх гэсэн иргэдийн ачааалал ихсдэг зэрэг шалтгаанаар аймгийн төвийн 9 багийн засаг дарга, түүний ажлын албатай хамтран 2016 онд төрсөн тайлант онд ерөнхий боловсролын сургуульд элсэн орох 583 хүүхдийн мэдээллийг эцэг, эхийн хаягнаас өөр хаягт бүртгэлтэй эсэхийг мэдээллийн сантай тулган шалгалаа. Үүнээс 116 хүүхдийн хаягийн мэдээлэл зөрүүтэй байсныг Иргэний улсын бүртгэлийн газарт жагсаалтаар хүргүүлэхээс гадна тухайн хүүхдийн эцэг эхтэй холбоо барьж, хүүхдийнхээ хаягийн мэдээллийг харьяа сумын улсын бүртгэгч дээр очиж шилжилт хөдөлгөөнөө бүртгүүлэхийг зөвлөлөө.

Мөн иргэний үнэмлэхээ шинээр захиалах иргэдийн мэдээлэл, мэдээллийн санд ургийн овог, эцэг, эхийн мэдээлэл зөрүүтэй байдлаас шалтгаалан мэдээлэл засагдах хүртэл хугацаа алдаж иргэний үнэмлэхээ захиалах асуудал нэлээд гарч байгаа учраас 2006 онд төрсөн 2022 онд 16 нас хүрч иргэний цахим үнэмлэх захиалах 13 сумын 755 иргэний хувийг хэргийг архиваас татан авч мэдээллийн сантай тулгах шалгах ажлыг зохион байгуулан ажиллаа. Үүнээс 170 иргэний мэдээлэл зарүүтэй байсныг ХААТР маягтуудыг цахимжуулан, нэрсийг Иргэний улсын бүртгэлийн газарт жагсаалтаар хүргүүлж мэдээллийн санд засвар оруулсан.

Хил зорчих үнэмлэхний бүртгэлийн эрх улсын бүртгэгч Х.Наранчимэгт нээгдсэн ба бүртгэл огт хийгдээгүй байна. Программын бэлэн байдал бүрэн биш, бэлдэц таарахгүй байгааг Иргэний бүртгэлийн газарт илтгэх хуудсаар мэдэгдсэн.

Мөн тасгийн хоёр улсын бүртгэгч аймгийн засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээний тасагт хүргэх мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг Х.Наранчимэг, улсын бүртгэгч Ц.Алтанцэцэг Иргэдийн төлөөлөгчийн хурлын тогтоолын хэрэгжилтийн тайланг тус тус хагас болон жилийн эцсийн байдлаар бичиж хүргүүлж байна.

1. Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр

Иргэний бүртгэлийн архивын санд орж ирж буй иргэний бүртгэлийн тоон мэдээг сар болгоны 25-ны өдрөөр тасалбар болгон мэдээ тайлангаа тогтмол гаргаж өгч байна. 2022 оны эхний хагас жилд иргэний гэр бүлийн байдлын болон иргэний бүртгэлийн чиглэлээр бүртгэлээс

ИУБ-11 төрөлт 1098 ширхэг ,

ИУБ-12 үрчлэлт 31 ширхэг,

ИУБ-13 овог эцэг-эх/-ийн нэр,нэр өөрчилсний бүртгэл 46 ширхэг,

ИУБ-14 эцэг /эх/ тогтоосны бүртгэл 66,

ИУБ-15 гэрлэлтийн бүртгэл 214 ширхэг,

ИУБ-16 гэрлэлт цуцалсаны бүртгэл 35 ширхэг,

ИУБ-18 нас баралт 277 ширхэг,

Аймаг нийслэл, сум баг хоорондын шилжин ирсэн маягт 509 ширхэг,

Регистерын дугаарын өөрчлөлтийн маягт маягт-25 6 ширхэг,

Засвар өөрчлөлт 18 ширхэг,

Иргэний үнэмлэх олголт ИУБ-21 маягт 2204 ширхэг,

Иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан ИУБ-31 2624 ширхэг, нийт 3821 ширхэг маягтуудыг журмын дагуу хүлээн авч баримтыг төрөлжүүлэн ангилан хувийн хэрэгт баяжилт хийсэн болно. Иргэн, төрийн болон төрийн бус байгууллага, хууль

хяналтын байгууллагуудаас ирсэн нийт 49 ширхэг албан тоотыг хүлээн авч холбогдох нотлох маягтуудыг хуулбарлан хүргүүлэв.




Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгж буюу хуудас баримт бичгүүдийг хэлтсийн дэргэдэх комиссын хурлаар хэлэлцэж баталсан шийдвэрийн дагуу 2020 оны баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгжийн жагсаалтыг бүрэн гүйцэт тоолон хадгалах хугацааны нэрийн жагсаалт үйлдэн 3295 хуудас баримт бичгүүдийг устгасан актыг 2022.03.22 өдөр 161 тоот албан бичгээр дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгж буюу хуудас баримт бичгүүдийг хэлтсийн дэргэдэх комиссын хурлаар хэлэлцэж баталсан шийдвэрийн дагуу 2020-12-31 ний өдөр хүртэлх баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгжийн жагсаалтыг бүрэн гүйцэт тоолон хадгалах хугацааны нэрийн жагсаалт үйлдэн 2543 хуудас баримт бичгүүдийг устгах саналыг 2021.11.09 өдөр 605 тоот албан бичиг хурлын тэмдэглэлийн хамт дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

БҮРЭН УСТГАСАН БАЙДАЛ



Архивын фондод баримт бичиг нягтлан шалгалтыг **712** хувийн хэрэгт хийж дахин боловсруулалт үйл ажиллагааг давхар хийж гүйцэтгэлээ.



ДОЛОО. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2022 оны жилийн эцсийн байдлаар дараах үйлчилгээг үзүүлээ. Иргэн, аж ахуй нэгжүүдэд эд хөрөнгө, бүртгэлийн чиглэлээр 4125 мэдүүлэг хүлээн авч заавар зөвлөгөөг өгсөн байна.

2022 оны 02 сараас эхлэн Мөнххаан, Эрдэнэцагаан сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч ажиллаж эхэлсэнээс сум орон нутагтаа нийт 450 мэдүүлэг хүлээн авч бүртгэл хөтөлсөн байна.

УБЕГазар нь цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар үйлчилгээний чанар хүртээмж шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд барьцааны гэрээ, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, барьцааны гэрээг дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх, эрхийн улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг хөнгөн шуурхай хялбар болгох ажлыг 2022 оны 06 сарын 02-ны өдрөөс эхлэн бүртгэсэнээс хойш нийт- 564 барьцааны гэрээ бүртгэсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь үйл ажиллагаанд хамаарах багц хуулиуд болон холбогдох тогтоол шийдвэр, журмуудын дагуу ажил үйлчилгээг явуулж байна. E-Mongolia, Opendata-аар дамжуулан эд хөрөнгө бүртгэлийн 102 лавлагаа иргэдэд олгосон байна.

Аймгийн 2021-2025 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2021 оны зорилтот тусгасан бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс судлан Киоск машин суурилуулах ажлыг Гэрэгэ ХХК-тай гэрээ хийж 8 сард суурьлуулснаас хойш нийт эд хөрөнгийн үйлчилгээ-253, үйлчилгээний хураамж-4,301,683 төгрөг оруулсан байна.

Иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх үүднээс газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн материалыг сумдын бүртгэгч нараар дамжуулан хүлээн авч ажиллаж байна.

Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа банк болон банк бус санхүүгийн байгууллагууд болон нотариатч нарт эд хөрөнгийн бүртгэл, хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон шинэчлэгдэн гарсан хууль, журмын талаар мэдээлэл хийж гарын авлага тарааж заавар, зөвлөгөө өгсөн.

Жилийн эцсийн байдлаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл нь дараах үйлчилгээ үзүүлсэн байна.

Төрөөс үнэгүй хувьчилсан газрын анхны бүртгэл нийт-409

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, шинээр баригдсан орон сууц нийт-291 бүртгэгдсэн.

- Худалдах гэрээ: 501
- Бэлэглэх гэрээ: 110
- Гэрээслэл, өв залгамжлах гэрээ:112
- Арилжих гэрээ:2
- Хамтран өмчлөгч өөрчлөх:69
- Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх:1
- Лавлагаа: 5
- Барьцаа гэрээ:1152
- Бүртгэлд өөрчлөлт оруулах:169
- Үрэгдүүлсэн гэрчилгээ:19
- Барьцааны гэрээ дуусгавар болгох: 1027
- Хувийн хэрэг хаах: 3

Үйлчилгээний хураамж- 88,519,262 төгрөг, тэмдэгтийн хураамж-2,409,320 төгрөг, 223,122,740 төгрөгийн татварын орлогыг аймаг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Нийт: 3928 мэдүүлэг хүлээн авч хувийн хэрэгт баяжилтийг хийж ажилласан. Эд хөрөнгийн улсын бүртгэлийн нэгдсэн архивт нийтдээ 15749 хувийн хэрэг хадгалагдаж байна. Сумдын бүртгэгчээр дамжуулан эд хөрөнгийн 135 бүртгэл хийсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт сар болгоны 25-ны өдөр мэдээгээ хүргүүлж байна.

2022 оны 10 сарын 18-ны өдрийн Сүхбаатар аймаг дахь улсын бүртгэлийн хэлтсийн даргын А/14 тоот тушаалын дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг тооллох комисс байгуулсаны дагуу эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч, тасгийн дарга мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч 4, хуулийн этгээдийн улсын бүртгэгч 1, нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй 15617 ширхэг хувийн хэргийг тооллож дуусгасан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний тасгаас Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж байгаа агентлаг төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын хүрээнд тус тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Г.Оюунжаргал “Хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт”, ЭХЭУБүртгэгч Б.Одонзул “Аймгийн засаг даргын захирамж, албан даалгаварын биелэлт”, Улсын ахлах бүртгэгч Ц.Мөнхчимэг “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, мөн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт”-ийг тус тус хариуцан тухай бүрд нь тайланг хүргүүлэн ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын чиглэлээр

2022 оны жилийн эцсийн байдлаар Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хувийн хэргийн тоо 15426, хувийн хэрэг үүнээс газраас бусад үл хөдлөх 7465, газар 7961, хадгалагдаж, жилийн эцсийн байдлаар архивт нийт 700 анхны баталгаажуулалт хувийн хэрэг шинээр нэмэгдсэн байна. Архиваас баяжилт болон хувийн хэрэг татахдаа захиалгын хуудсаар гаргаж журналд бүртгэл хөтлөж, өдөр тутамд гарч

байгаа шинэ хувийн хэргийг тухай бүр программд шивж оруулах асуудлыг тасгийн дарга бүрэн хариуцаж ажиллаж байна.

Эд хөрөнгө хуулийн этгээдийн архивын мэдээг сар бүрийн 25-нд Ерөнхий газарт цаг тухай бүрд нь хугацаа хоцроохгүй хүргүүлэн ажиллаж байна. Архиваас 64 иргэнд нотлох баримтаас хуулбар олголоо.

НАЙМ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон түүнийг дагалдан гарсан журмууд, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, ХЭБГ болон ХШГ-аас ирүүлсэн чиглэл, зөвлөмжүүдийг бүртгэл хөтлөх үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 245 дугаар тогтоол, Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 сарын 14-ний А/02 тоот тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”, УБЕГ-н даргын “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загвар, индекс, код батлах тухай” 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/55 дугаар тушаал, Засгийн газрын 230 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллаа.

Тайлант хугацаанд орон нутгийн өмчийн тооллоготой холбоотойгоор хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгүүлээгүй, зөрчилтэй төрийн байгууллагуудыг бүртгэлд хамруулахажлыг зохион байгуулан нийт 32 төрийн байгууллага гүйцэтгэх удирдлагын мэдээлэлд орсон өөрчлөлтөө бүртгүүллээ.

Улсын Их Хурлын 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж

мөрдөх журмын тухай хуулийг тус тус баталсантай холбогдуулан тус хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 04 сарын 26-ны өдрийн 1/3681 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг хяналтандаа авчэцсийн өмчлөгчийн мэдээллийг нөхөн бүртгэх ажлыг эрчимжүүлэх ажлыг төлөвлөгөө гарган батлуулж, нийт 13 суманд хэлтсийн нийт улсын бүртгэгчдээр дамжуулан утсаар холбогдох, орон нутгийн телевиз болон цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх байдлаар хамтран зохион байгуулж хэрэгжүүллээ. Эцсийн өмчлөгчийн нөхөн бүртгэлд хамрагдах шаардлагатай нийт хуулийн этгээдээс өссөн дүнгээр 519 хуулийн этгээдийг хамруулаад байна.

Хоршооны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 40 дүгээр тогтоол гарсан. Энэхүү хууль, тогтоол болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын даргын 2022.05.17-ны өдрийн 5/4327 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг удирлага болгон хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, хоршооны шинэчилсэн дүрмийг улсын бүртгэлд бүртгэх, эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутаг дахь Хоршоодын нэгдсэн холбоо, ХХААГ-н ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, хоршоодын дарга нартай хамтран ажиллаж байна. Одоогоор 12 хоршоо нь шинэчилсэн дүрмээ бүртгүүлээд байна.

2022 онд иргэн, хуулийн этгээдээс нийт 469 өргөдөл хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн.

Шинээр байгуулагдсан хуулийн этгээд 59 бүртгэгдсэнээс:

ХХК	38
Холбоо НҮТББ	8
Холбоо ҮЭБ	1
Нөхөрлөл ЗБН	9
Хоршоо	1
ААТҮГ	2

тус тус улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Мөн шинэчилсэн бүртгэлд Төрийн байгууллага, албан газар хэлбэртэй хуулийн этгээд 1 –ийг хамруулсан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.11.01-ний өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-д заасны дагуу 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыгүйл ажиллагаа эрхэлдэг тухайн орон нутагт бүртгэж эхэлсэн. Үүний дагуу хуулийн этгээдийн салбарыг шинээр бүртгэх болон мэдээлэлд орсон өөрчлөлтийг тус нэгж дээр хүлээн авч бүртгэн, бүртгэлийн эх нотлох баримт бичгийг дугаарлан цахимжуулж хувийн хэргийг нь харьяалагдах нэгжийн архивт шилжүүлэн ажилласан байна. Үүнд: Шинээр байгуулагдсан Салбар төлөөлөгчийн газрын бүртгэл -5, Салбар төлөөлөгчийн газрын бүртгэлд орсон өөрчлөлт -3 бүртгэгдсэн.

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт давхардсан тоогоорнийт 117-г бүртгэсэн байна. Үүнийг бүртгэлийн төрлөөр авч үзвэл:

Үүсгэн байгуулагч /хувьцаа эзэмшигч/-ийн өөрчлөлт - 17

Гүйцэтгэх удирлагын өөрчлөлт -52

Эцсийн өмчлөгч шинээр, нөхөн, өөрчлөлт бүртгэсэн -121

Хариуцлагын хэлбэр өөрчилсөн -0,

Эрхлэх үйл ажиллагааны чиглэл өөрчлөлт – 23

Дүрэм, гэрээ шинэчлэх – 38,

Шилжилт хөдөлгөөн хийсэн 1,

Гэрчилгээ дахин олгосон 18,

Оноосон нэр өөрчлөлт 11,

Татан буугдаж улсын бүртгэлээс хасалт хийгдсэн 0байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн системээр болон и-монголиа системээр иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 406 оноосон нэрийн давхардлыг шүүж, үүнээс 101 нэрийг сүлжээнд шинээр баталгаажуулж, оноосон нэрийг өөрчилсөн 11, хугацаа сунгасан 1 баталгаажуулалтбүртгэсэн байна.

Хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад тамга, тэмдгийн хяналтын дугаар шинээр болон дахин нийт 88 олгож, 22 хуулийн этгээдээс тамга тэмдгийг хураан авч архивчд хүлээлгэн өгсөн.

Иргэн хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтээр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 29 лавлагаа олгосон байна.Үүнээс: Хууль хяналтын байгууллагад 2, иргэн, хуулийн этгээдэд 27 лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, баримт бичгийн олголтыг 195 иргэнд хийсэн байна.

Тайлангийн хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой нэхэмжлэлтэй шүүхээр хянагдаж байгаа болон Шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй хэрэг маргаан гараагүй байна.

Иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор Улсын бүртгэлийн хууль тогтоомж, мэдээ мэдээллийг олон нийтийн цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлан ажилласан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ERS шинэ системтэй холбоотой гарсан зөрчил, алдаа дутагдлыг бүртгэл хийх явцад илрүүлэн, тухайн асуудлыг шийдвэрлэх талаарх саналыг тухай бүрт нь зургаар баталгаажуулан системийн хөгжүүлэлтийн баг болон хариуцсан улсын бүртгэгчид илгээсэн.

Хууль зүйн сайдын 2018.02.13-ны өдрийн А/24 дүгээр баталсан “Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам” –ын дагуу сар бүр хуулийн этгээдийн тоон мэдээг хугацаанд нь тогтмол гаргаж ХЭБГ-т хүргүүлэн ажилласан. Мөн тоон мэдээний батлагдсан загварт тусгагддаггүй мэдээллийг оруулах тал дээр ХЭБГ-т саналаа хүргүүлсэн.

ХЭБГ-с болон ХШГ-аас ирүүлсэн чиглэл, албан даалгавар, мэдээлэл судалгааг цаг тухай бүрт нь хийж хүргүүлсэн.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017.12.06-ны өдрийн А/1021 дүгээр тушаалаар баталсан “Үйлчилгээний орлогын мэдээний маягт, маягт нөхөх зааврыг батлах тухай” журмын дагуу Үйлчилгээний орлогын мэдээ болон үнэт цаасны тайланг сар бүр тогтоосон хугацаанд нь гаргаж санхүүд өгч,алдаа зөрчилгүй ажилласан.

ЕС. САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тус хэлтэс нь 2022 оны 05-р сарын санхүүжилтээр улсын төсвөөс нийт 172.3 сая төгрөгийн санхүүжилт авч зарлагаар 159.7 сая төгрөгийн зардал гарч үлдэгдэл 12.6 үлдэгдэлтэй, нэмэлт санхүүжилтээр 3.9 сая төгрөгийн санхүүжилт авч 0.9 сая төгрөгийн зардал гаргаж үлдэгдэл 3.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй ил тод хүргэн ажиллаж байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 43.8 сая төгрөгийн орлого орж улсын төсөвт 43.3 сая төгрөгийг төвлөрүүлэн орлогын үлдэгдлээр 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, Үнэт цаасны тайланг 13 сум болон төвийн улсын бүртгэгч нарын үнэт цаас зарцуулалтын тайлан, сар бүрийн орлогын мэдээг сар бүрийн эхэнд гаргаж хуулийн хугацаанд хугацаа хоцроохгүй УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Хүчингүй болсон үнэт цаас маягыг бүртгэгч тус бүрээс авч жагсаалт үйлдүүлэн хүчингүй болсон шалтгааныг тодруулж хэрэв бүртгэгчийн буруугаас болсон бол төлбөрийг барагдуулан ажиллаж байна. Хүчингүй болсон үнэт цаас маягыг жилийн эцэст нэг удаа устгалд оруулж байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны төсөв, 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн төрийн аудитын дүгнэлт, бусад мэдээ мэдээлэл болон ил тод байх бүх мэдээг хуулийн хүрээнд хуулийн хугацаанд бүх мэдээлэл үнэн зөв байршуулсан ба хоцорсон болон хугацаа хоцрооч байршуулсан мэдээлэл байхгүй болно.

Орон нутгаас албан хаагчдын тав тухтай ажиллах байрны асуудлыг шийдвэрлүүлж өрөө тасалгаануудыг тохижуулж албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулан ажиллаж байна.

Иргэдэд түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэх үүднээс 2021 онд КИОСК машиныг Гэрэгэ системс ХХК-тай 3.5 сая төгрөгөөр гэрээ хийн аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан ажилласан. 2022 оны 06-р сарын 02-ноос хаан банктай

гэрээ хийн пос машинаар иргэдэд хүндрэл чирэгдэл учруулахгүй түргэн шуурхай үйлчилж байна.

2022 онд “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын хүрээнд хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгчээр ажлын хэсгийн 3 хүний бүрэлдэхүүнтэй тушаал гаргуулж үндсэн хөрөнгө болон газар, байшинг тооллогын комиссын тооллогоор нэг бүрчлэн үзэж тоолж “ төрийн өмчийн тооллогын программд шивж оруулан Монгол улсын засгийн газрийн 2020 оны 9 дүгээр тогтоол, 2020 оны ТӨБЗГ-ын А-1\ 2179 албан бичиг, 2022 оны ТӨБЗГ-ын 64 дүгээр тогтоол, Аймгийн орон нутгийн өмчийн газрын заавар, чиглэлийг ханган ажилласан.


Хэлтсийн батлагдан ирсэн төсвийг төсвийн хэмнэлттэй ,тэвчиж болох зардлыг тэвчиж үр ашигтай өр, авлага үүсгэхгүй хэлтсийн үйл ажиллагаанд зөв тооцон олон нийтэд хүртээмжтэй үр өгөөжтэй байх тал дээр анхааран ажиллаж байна.

АРАВ. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР


Хуульзүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 дүгээрсарын 14-ний өдрийн А/02 тоот тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам/”-ыг мөрдлөг болгож, мэдээллийн технологийн төлөвлөгөө гаргаж, хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн УБХ-ийн тоног төхөөрөмжийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дотоод сүлжээ, интернэт сүлжээ, бүх албан хаагчид, сумдын бүртгэгч нарын компьютер, принтер, каноны хэвийн үйл ажиллагаанд байнгын бэлэн байдалыг ханган тухай бүрт нь засаж сэлбэн, шинээр сольж ажиллаж байна. Улиралд 1 удаа хэлтсийн албан хаагчдын суурин болон зөөврийн компьютеруудын тоос тоосонцорыг цэвэрлэн ажиллаж байна. 2022 онд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмж давхардсан тоогоор нийт 25 удаа засвар үйлчилгээг хийсэн. УБЕГ-аас ашиглагдаж байсан нөүтбүүк 2 ш, хурууны хээ уншигч скайнер 2 ширхэгийг олгосон. Ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын зүгээс программ хангамж болон техник хангамжийн шинэчлэл, сайжруулалтын ажлыг байнга хийдэг бөгөөд “Улсын бүртгэлийн байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх замаар иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх төсөл”-ийн хүрээнд бүртгэлийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, анхан шатны нэгжүүдийн тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх зэрэг ажлуудыг тогтмол хийдэг. 2021 онд олгогдсон БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар аймгийн 13 сумын улсын бүртгэгч нарт компьютер 13 ширхэг, 3 үйлдэлт принтер 13 ширхэг, хурууны хээ уншигч 13 ширхэг, зургийн аппарат 13 ширхэг зэрэг тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилсэн бөгөөд тус бүрийн тоног төхөрөмжийн системийн хэвийн үйл ажиллагаа программ хангамж зэргийг бүрэн суулган ажиллах нөхцөлийн бүрдүүлэн ажиллаж байна.




Хэлтэсээс зохион байгуулсан үйл ажиллагаа болон УБЕГазраас зохион байгуулсан мэдээ мэдээлэл, санхүү хүний нөөц, сарын бүрийн тоон мэдээлэл, өргөдөл гомдлын мэдээлэл, имфографик мэдээлэл, видео мэдээ зэргийг цаг тухай бүрт нь www.sukhbaatar.burtgel.gov.mn, www.facebook.com/sukhbaatarburtgel гэсэн цахим хуудаснаа нийтлэн ажиллаж байна.



Хэлтсийн дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангах хүрээнд илүү ашиглах шаардлагагүй сүлжээний кабел утасгүй эмх цэгцтэй шинээр ил гарсан утсуудыг бүрэн далдалсан. Сүхбаатар аймгийн 13 сум, хэлтсийн хэмжээнд бүртгэлийн ерөнхий сүлжээ нь Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ын сүлжээгээр хангагдаж ажиллагааг бүрэн хэвийн ажиллаж байна.



Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс 2022.05.02-ний өдрөөс эхлэн Монгол улсын 16 ба түүнээс дээш насны иргэдэд харъяалал харгалзахгүйгээр 13 сумын болон төвийн иргэний бүртгэлийн ажилтануудаар дамжуулан тоон гарын үсэг иргэний цахим үнэмлэхэнд олгож эхэллээ. Уг ажлын хүрээнд бүртгэгч нарын тоон гарын үсэг олгох ажлыг саадгүй явуулах нөхцөл бололцоог ханган компьютер тоног төхөөрөмжид шаардлагатай программ хангамжуудыг суулган хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.



Сумдын бүртгэгчид амаржсаны болон жирэмсэний амралт эдлэх, өндөр насны тэтгэвэрт гарах, урт хугацаагаар сургалтанд явахад тоног төхөөрөмжинд үзлэг хийж шалгаж авч, дараагийн бүртгэгчид хүлээлгэн өгч, хүлээлцсэн тухай тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд харьцаж ажиллаж байгаа албан хаагчдад ажлын хэрэгцээнд ашиглаж байгаа программ хангамжид хандан нэвтрэх нууц үгээ тодорхой хугацаанд буюу улиралд заавал сольж байх, нууц үгийн бүрдэл нь том, бага, үсэг, тоо, тусгай тэмдэгт хослуулсан байхыг зөвлөж ажиллаж байна. Мэдээлэл алдахгүй байх аюулгүй байдлыг хангах зорилгоор компьютерт гадны зөөврийн диск, флэш оруулах портуудыг хааж, зөвхөн дундаа мэдээлэл солилцохоор дотоод сүлжээний Lan messenger, 100 нэгдсэн шэйрийг ашиглаж хэвшсэн. Албан хаагчдад тогь тасарсан үед тог баригчаа унтраах, ажил тарсны дараа компьютерээ бүрэн унтраах бусад тоног төхөөрөмжүүдийг зөв, зохистой хэрэглэх талаар байнга зөвлөгөө өгч ажиллаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН :

УЛСЫН БҮРТГЭГЧ /Х.НАРАНЧИМЭГ/

УЛСЫН БҮРТГЭГЧ /Г.ОЮУНЖАРГАЛ/

ХЯНАСАН:

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ /Н.БАДРАХЦОГ/